

## “ЖАМБАЛДОРЖИЙН” ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

У.ЭРДЭНЭБАТ<sup>1</sup>, Т.БАТБАЯР<sup>2</sup>

<sup>1</sup>МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологи-ийн тэнхим,

e-mail: u\_erdenebat@yahoo.com,

<sup>2</sup>ШУА-ийн Археологийн хүрээлэн,

e-mail: bayaraa\_555@yahoo.com

*Түлхүүр үгс:* Түрэгийн үе, Умай, Орхоны хөндий, Өвөрхангай, Хужирт, Дулаанхайрхан, Жамбалдорж хүн чулуун хөшөө, тахилын онгон

**ТОВЧ АГУУЛГА:** Энэхүү тэмдэглэлд Өвөрхангай аймгийн Хужирт сумын нутгаас шинээр олдсон, нутгийн ард олны “Жамбалдорж” хэмээн нэрлэдэг, шинжлэх ухаанд урьд өмнө тэмдэглэгдээгүй байсан нэгэн хүн чулуу, түүний дэргэд орших тахилын онгоны үлдэгдлийн тухай судалгааны мэдээллийг анх удаа олон нийтэд толилуулж байна. Энэ дурсгал манай орны нутаг дэвсгэрт орших Түрэгийн үеийн тахилын онгон, хүн чулуун хөшөөтэй ерөнхийдөө ижил төстэй боловч байрилын хувьд уулын орой дээр, тэгш өндөрлөг газар, хадны хөмгийн дэргэд байгуулснаараа нэн өвөрмөц болно.

2006 оны 4 сарын 24-нд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны секторт хандаж Өвөрхангай аймгийн Хужирт сумын Засаг дарга Р.Лхагвасүрэнгээс албан бичиг ирүүлж: “Тус сумын нэгдүгээр багийн нутаг дэвсгэр Дулаанхайрхан уулын өвөр Ар хадаргантайн эхэнд түүхийн дурсгалт чулуун хөшөө байдаг. Энэ нь сумын түүх дурсгалын бүртгэлд бүртгэгдсэн. Одоогоор судалгаа шинжилгээ хийгдээгүй нас, цаг хугацаа нь үл мэдэгдэх, нутгийн иргэдийн дунд домог яриа төдий байгаа болно. Иймд судалгаа шинжилгээ хийж улсын түүх соёлын дурсгалын бүртгэлд бүртгэж өгнө үү” хэмээн хүссэн билээ.

Энэхүү мэдээллийн мөрөөр Монголын эртний нийслэл Хархорумыг археологийн талаар шинжлэн судлаж буй Монгол-Германы Орхон Экспедицийн хээрийн шинжилгээний ажлын дашрамд 2008 оны 8 сарын 23-нд нутгийн малчин ардуудаар газарчлуулан чулуун хөшөө байгаа газрыг сурвалжлан олж анхны хэмжилт, зураглал үйлдэн баримтжуулсан юм (Эрдэнэбат, Батбаяр, 2008).

Уг дурсгал Өвөрхангай аймгийн Хужирт сумын нэгдүгээр багийн нутаг, Дулаан хайрхан уулын өвөр, Ар хадаргантайн эх, Хуурай улаан хадны амны энгэрт орших өндөрлөг дэвсэг дээр, баруунаас зүүнш сунаж тогтсон ханан хадны төв голын урагшаа харсан нэгэн жижгэвтэр хонгилд оршиж байв (Зураг 1). Нутгийн өвгөд хуучин энэ газрыг Хүн чулууны энгэр гэж нэрлэдэг байсан гэх бөгөөд 1990-ээд оноос хойш шашин номын үйл ажиллагаа чөлөөтэй болсноор Жамбалдорж бурхан хэмээн шүтэж, зул хүж өргөж, шар тос, идээ цайны дээжээр мялаах болжээ. Энэ газар Хархорин сумын төвөөс зүүн урагш, шулуун шугамаар

## ЖАМБАЛДОРЖИЙН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

29,6 км, Хужирт сумын төвөөс зүүн урагш 30 орчим км зайтай, Хөшөө Цайдам дахь Түрэгийн алдарт жанжин Культегиний тахилын онгоноос азимутын 165° чиглэлд 52,3 км зайтай орших ба урагш бараалахад Хуурай, Тосонгийн даваа, Өрмөгт, Жаргалантын нуруу зэрэг орчны уулс тодорхой харагдана.




Зураг 1а. Монгол улс, Өвөрхангай аймаг, Хужирт сум, Дулаанхайрхан, Жамбалдорж



Зураг 1б. Өвөрхангай аймгийн Хужирт сумын Дулаанхайрханы өврийн “Жамбалдорж” хүн чулуун хөшөө



*Зураг 2а. Өвөрхангай, Хужирт, Дулаанхайрханы өвөр,  
Хүн чулуун хөшөөний гэрэл зураг*



*Зураг 2б. Өвөрхангай, Хужирт, Дулаанхайрханы өвөр,  
Хүн чулуун хөшөөний гар зураг*

Хонгилын үүд чанх урагшаа харсан, 170 см өндөр, оройгоороо 38 см, ёроолоор 90 см өргөн, доторх хөндий орон зай 60-120 см хэмжээтэй. Хонгилын

## ЖАМБАЛДОРЖИЙН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

доторхи зайд голлуулан хавтгай хадаар суурь хийж, нэгэн хүн чулууны нүүрийг нь урагш хандуулан босгон тавьсан байх бөгөөд хүзүүнд нь эрих зүүлгэж, их биеийг нь хадгаар битүү ороож шар тосоор шавсан байлаа. Хүн чулууны зөвхөн нүүр хэсэг ил харагдах бөгөөд хүний нүд чих, хамар ам, хацар шанааг тодорхой дүрсэлсэн нь мэдэгдэж байв. Хүний нүд хамрыг нэг үргэлжилсэн шугамаар гаргасан бөгөөд толгойд өмссөн шовгор оройтой малгайг ховил гарган тодорхой харуулжээ. Чихний омрууг мөн тодорхой гаргасан бөгөөд зүүсэн ээмэг мэдэгдэхгүй. Хүн чулууны байршлыг GPS багажаар тодорхойлбол: умард өргөрөгийн N 46°49'38.0'', дорнод уртгагийн E 103°09'31.0'', далайн түвшнээс дээш 2084 метр өндөрт оршиж байв.


Хонгил дотор хүн чулууг байрлуулахдаа хөмгийн шалыг тэгшлэн доор нь суурь болгон дунджаар 50 см урт, 15 см өргөн, 10 см орчим зузаан хавтгай хадыг 3-4 үе дөрвөлжлөн засаж тавцан хийсэн ба энэхүү суурин дээр хүн чулууг босгож тогтоосон байв. Эдгээр чулууны завсар зайд хадны хонгил дотор нутгийн сүсэгтэн олны өргөсөн арц хүж, цай идээ, мөнгө зоосны зүйл ба самбай хадаг, сэвтсэн бурханы зурмал хөрөг зэрэг зүйл байлаа.

Хүн чулууны байдлыг үзвэл саарал өнгийн боржин чулуугаар үйлдсэн бөгөөд толгой цээж үргэлж, харин бүсэлхийнээс дооших хэсэг хугарч алга болжээ. Хүний нүүр монголжуу төрхийн, өргөн шанаатай, жижиг дугуй нүдтэй, унжуу урт хамартай, нарийн уруулаа жимийсэн, сахал үс мэдэгдэхгүй. Толгойдоо шовгор оройтой тоорцог маягийн малгай өмссөн мэт. Биед нь ямар нэг зэмсэг зүүлт юмуу дээл хувцас огт мэдэгдэхгүй. Харин цээжинд хоёр жижиг зэрэгцээ товгор гаргаж хөхийг дүрсэлснээс үзвэл нүцгэн байгаа бололтой гэмээр. Хүний гэдэс яльгүй цүзгэр. Хоёр гарыг гэдэсний өмнө хүйсэн тушаа авч ямар нэг сав барьснаар дүрсэлсэн нь маш элэгдэж мөлийсөн байв. Хүний биеийн ерөнхий харьцаа, сахалгүй, бас хөх дүрсэлснээс үзвэл эмэгтэй хүнийг дүрсэлсэн бололтой. Хэмжээ (хугархай): 71 см өндөр, 25 см өргөн, 25 см зузаан юм (Зураг 2).

Дулаан хайрхан уулын өвөр дэх энэхүү хүн чулуу бүхий хонгил орших хадны дэргэд, түүний урд талд 20 орчим метр зайтай бусдаас онцгой сондгой ганц удган мод (нарс) байх бөгөөд бид орчны газрыг нарийвчлан шалгаж үзэхэд хонгил ба түүний урд буй удган мод хоёрын яг гол дунд өвсөн дундаас хэсэг чулуун өрлөг цухуйж байв. Энэхүү өрлөг дөрвөлжин хэлбэртэй, баруунаас зүүнш 116 см, хойноос урагш 94 см хэмжээтэй. Гонзгой чулууг дөрвөлжлөн өрсөн намхан хашлага байх бөгөөд баруун урд хэсгийн чулуу анхны байрнаас хөдөлж хөндөгдсөн шинжтэй байлаа. Дөрвөлжин хашлагын дотор зүүн талд нь нэгэн дугуй хэлбэртэй чулуу цухуйж байсныг үзвэл, мөнөөх хадны хонгилд тавьсан хугархай хүн чулууны доод биеийн хэсэг анхны байдлаар газарт булаатай байв (Зураг 3).



*Зураг 3а. Өвөрхангай, Хужирт, Дулаанхайрханы өвөр,  
Тахилын онгоны бүрэлдэхүүн хэсэг  
Хүн чулуун хөшөөний суурь бүхий хашлага чулууны гэрэл зураг*



*Зураг 3б. Өвөрхангай, Хужирт, Дулаанхайрханы өвөр,  
Тахилын онгоны бүрэлдэхүүн хэсэг  
Хүн чулуун хөшөөний суурь бүхий хашлага чулууны  
дэвсгэр зураг*

Манай улсын нутагт явуулсан археологийн судалгааны явцад Түрэгийн үеийн тахилын онгоны хашлага дотор хүн чулууг нь байрлуулсан баримт нэг бус удаа олдож байжээ. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг, Алтай сумын Чигэртэй гол, Ховд аймгийн Манхан сумын Сэрүүн, Мөст сумын Бодончийн гол зэрэг газар байгаа тахилын онгонд ийм зохион байгуулалт буй юм.

Бид учирсан орон зай, цаг хугацааны нөхцөл байдлаас шалтгаалж хүн чулууны суурийг малтаж хэмжилт тодорхойлолт хийж амжсангүй. Дулаанхайрхан уулын өвөрт орших энэхүү хүн чулууг урьд өмнө эрдэмтэд археологийн талаар хэмжиж тодорхойлж байгаагүй бөгөөд ерөнхий хийц дүрслэл ба зохион байгуулалтын онцлогоор үзэхэд VI-VIII зууны Түрэгийн хаант улсын үед холбогдох тахилын онгоны дурсгал бололтой. Гэвч байршлын хувьд уулын энгэрт, бараг орой дээр нь шахуу нилээд өндөр газар байрласан төдийгүй урагшаа харсан эхийн умай хэлбэрт хадны ангархай хонгилыг зориуд оноож байгуулснаараа нэн өвөрмөц байна.

Түрэгийн шашин шүтлэгийн тухай Умард Чжоу (556-581) улсын нангиад сударчийн тэмдэглэсэн бичгийн сурвалжийн мэдээнд, түрэгийн хаад язгууртан нар жил бүрийн таван сарын дунд арав хоногт Орхоны хөндийгөөс холгүй Тамир голын савд хуран цугларч Этүгэн уулын биед орших өвөг дээдсийн нэгэн ариун агуйг тахидаг байсан хэмээн өгүүлдэг (Liu-Mau-Tsai, 1958: 10). Энэ нь Орхоны түрэгүүдийн шүтлэгийн гол нэгэн тэнгэр болох Умайн тахилгатай холбоотой содон дурсгал байж болзошгүй бөгөөд энэ хавийн нутагт Эрдэнэ зуугийн орчим Умайн ам (Хархорин сум), Төвхөн хийдийн ойр Умайн агуй (Бат-Өлзийт сум) зэрэг эхийн ариун умай хэвэлтэй холбоотой газар усыг одоо болтол нутгийн зон олон эрхэмлэн хүндэлсээр байгаа нь Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн цаг үеэс бүр өмнө VI-VIII зууны үед Орхоны хөндийд хөх түрэгүүд нутаглаж байх үеийн шүтлэгийн улбаа бололтой.

## НОМ ЗҮЙ

*Эрдэнэбат У., Батбаяр Т., 2008. Монгол-Германы Орхон Экспедицийн 2008 оны хээрийн шинжилгээний тайлан. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.*

*Liu-Mau-Tsai. 1958. Die chinesischen Nachrichten zur Geschichte der Ost-Tuerken (T'u-kuee). I. Buch: Texte. In: Goettinger Asiatische Forschungen. Bd. 10, Otto Harrassowitz, Wiesbaden.*

## ABSTRACT

**U.Erdenebat, T.Batbayar**

### THE NOTE ON THE “JAMBALDORJI”

The paper is offered to publicate materials of a newly-found stone statue near the Mount Dulaan Khairkhan, wich located on the territory of Khujirt soum, Uvurkhangai aimak. It was registered by Mongolian-German Joint “Orkhon” Expeditions Team in 2008. The autors present that the stone statue can be date back to Turkic Period (VI-VIII centuries).